**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 28 өдөр Дугаар А/36 Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй
болгох, түдгэлзүүлэх, нэр шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтууд, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын “Баатар ван өрлөг” ХХК-ий хүнсний дэлгүүр, “Их Хан сүлд” ХХК-ий зоогийн газар, “Цэцэн хан өлгий” ХХК-ий баар, Дадал сумын “Шинэ түвшин ундрах” ХХК-ий хүнсний дэлгүүр, Бор-Өндөр сумын “Номхон халиун” нөхөрлөлийн хүсний дэлгүүр, Биндэр сумын “Баргажин байд” ХХК-ий хүнсний дэлгүүрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар олгосугай.

2. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатайгаар сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

1. Хэрлэн сум “Өсөх Оршихуй” ХХК
2. Хэрлэн сум “Өргөө онон” ХХК
3. Хэрлэн сум “Умардын Од” ХХК
4. Хэрлэн сум “Очир эх” ХХК
5. Хэрлэн сум “Тамир Өсөх” хоршоо
6. Хэрлэн сум “Их ханан” ХХК
7. Бор-Өндөр сум “Дагшинбумба” ХХК
8. Биндэр сум “Наранхул” ХХК
9. Дархан сум “Үлэмж орших” хоршоо
10. Дархан сум “Дэнжийн өндөр” ХХК
11. Дархан сум “Дархан-Ушир” ХХК
12. Цэнхэрмандал сум “Нугаар хайрхан” ХХК
13. Цэнхэрмандал сум “Наран баац” ХХК
14. Бор-өндөр сум “Сингэл трейд” ХХК

23101017б

14. Баян-Адарга сум "Цэн эрхэт" ХХК
15. Баян-Адарга сум "Мөнхийн дуурлиг" ХХК
16. Дадал сум "Бурхан халдун мянгат" ХХК
17. Батноров сум "Хунт хийморь" ХХК
18. Норовлин сум "Онон улз" ХХК

Баар:

19. Биндэр сум "Наранхул" ХХК
20. Жаргалтхаан сум "Шар асга" ХХК
21. Баян-Овоо сум "Зуун сарнай" ХХК
22. Дархан сум "Дархан-Ушир" ХХК
23. Жаргалтхаан сум "Оюу хан мөрөн" ХХК

Зоогийн газар:

24. Бор-Өндөр сум "Дэлгэр нуур" ХХК

3. Хэрлэн сумын "Оч манлай" ХХК-ий баар, Биндэр сумын "Баргажин байд" ХХК-ий баарны согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс хүчингүй болгосугай.

4. Хэрлэн сумын Биг оргил" ХХК-ий баарны согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 01 дүгээр сарын 28ны өдрөөс эхлэн 3 сар хүртлэх хугацаатайгаар түдгэлзүүлсүгэй.

5. Бор-Өндөр сумын "Дагданжаргалан" ХХК-ий согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Мөнхжаргал овогтой Болортуяад шилжүүлсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комисс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандарт, хэмжилзүйн хэлтэс, Татварын хэлтэс, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБА